

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Төрийн аудитын байгууллага улс орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах үүднээс төсвийн удирдлагийг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байж, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.

Хууль хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

1. Шилэн дансны хууль батлагдан 2015 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан шилэн дансныг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан
2. Монгол Улсын Ерөнхий Аудитор төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нарт шилэн дансны тухай хуулийн хүрээнд илтгэл тавьсан.
3. Төрийн аудитын байгууллага өөрийн цахим хуудас болох www.audit.mn сайтад Үндэсний аудитын байгууллага, аймаг, нийслэлийн төсвийн шууд захирагч нар, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагч гээд нийт 24 дэд меню бүхий шилэн дансны менюг үүсгэсэн.
4. “audit.mn” сайтын цэсэнд:
 - Тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан;
 - Өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалагдаж байхаар өөрчилж, сайтад мэдээллийн сан архивлагдан харагдаж байх нөхцлийг бүрдүүлсэн;
 - Шилэн дансны хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг үндэслэн төрийн аудитын байгууллагын төсөв санхүүгийн мэдээллүүдийг бүрэн тайлагнахуйц 19 менюг тусгайлан гаргаж байршуулсан.
 - Мөн төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нар улирал бүрийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг байршуулж байхаар “байгууллага” цэсэнд нэмж оруулсан.
5. Цахим хуудаст Ерөнхийлөн захирагч, Төвлөрүүлэн захирагч, Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газруудын шууд захирагч нар төсөв, санхүүгийн мэдээллийг тухай бүр шууд оруулах боломжийг бүрдүүлж, дэд цэсүүд шинээр нээсэн.

6. Төсөв, санхүүгийн бүх мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, бүрэн, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр оруулж тогтмолжуулсан
7. Дээд шатны төсөв захирагч нь шууд захирагч нарын “ШИЛЭН ДАНС”-ний мэдээллийг хугацаанд нь, бүрэн, үнэн зөв оруулсан эсэхэд тогтмол хяналт тавин, бүртгэл хийн ажиллаж байна.
8. Удирдах ажилтны зөвөлгөөнд Сангийн яамны Төрийн сангийн төлбөр тооцооны хэлтсийн дарга Б.Отгонцэцэг “ШИЛЭН ДАНС”-ны хэрэгжилт, арга зүйн зөвлөгөө өгч, “Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” номыг 400 ширхэгийг ТАБ-ын холбогдох албан тушаалтнуудад гарын авлага болгохоор тараасан.
9. Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн шууд захирагч нарт албан бичиг хүргүүлэн улирал бүр Шилэн дансны тайланг гаргаж нэгтгэн Сангийн яаманд хүргэх талаар мэдээлсэн. Энэ дагуу улирал бүр тайланг хүргүүлж байх болно.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ /60ХОНОГ/

Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхлээд 2 сар буюу 60 хоног болж байна. Энэ хугацаанд хуулийн хэрэгжилтийн талаар танилцуулахад:

№	Аймгуудын нэр	Шилэн дансны тухай хууль, журмын дагуу байршуулах мэдээлэл			Тайлбар
		Өөрийн цахим хуудсанд шилэн данс цэс байршуулсан эсэх	Нийт тавих 11 мэдээллээс байршуулсан мэдээллийн тоо	Нэгдсэн цахим хуудаст мэдээлэл тавьсан эсэх	
1	Төрийн аудитын байгууллага	тийм	19-6	<i>shilendans.gov.mn сайтад ерөнхийлөн захирагчийн нэгдсэн цэс байхгүй. Шууд захирагч тус бүрээр харагдаж байгаа.</i>	Shilendans.gov.mn сайтад шууд захирагч нарын 1.Төсвийн гүйцэтгэл цэсэнд одоогийн байдлаар ТАБ-аас оруулах ёстой дараах

2	Төвлөрүүлэн захирагч	тийм	19-6	11-9	мэдээллийг оруулсан. - Төсөв захирагчийн гүйцэтгэлийн хэмжих тоон болон чанарын үзүүлэлт хүрсэн үр дүн - Төсөв гүйцэтгэл - Цалингаас бусад 5 саяаас дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ оруулсан. 2. <i>Хөрөнгө оруулалт</i> цэсэнд 2015 онд ТАБ-ын хэмжээнд хөрөнгө оруулалт төсөвт тусгагдаагүй учир мэдээлэл байхгүй 3 <i>Тендер худалдан авалт</i> цэсэнд одоогийн байдлаар тендер зарлаагүй учраас мэдээлэл оруулаагүй 4 <i>Үнэт цаас</i> цэсэнд ТАБ-д оруулах мэдээлэл байхгүй 5. <i>Байгууллага</i> цэсэнд 1 мэдээлэл оруулсан -Төсөв, өмч хөрөнгө, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 7 хоногийн дотор /Ерөнхий аудиторын тушаалыг/ оруулсан. Дараах цэсний мэдээллүүд Хугацаа болоогүй учир ороогүй - Хандив ,тусламж зарцуулалтын тайлан дараа жилийн 04 дүгээр сарын 25-ний өдрийн дотор ,хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ний дотор
3	ҮАГазар	тийм	19-6	11-9	
4	Архангай	тийм	19-3	11-9	
5	Баян-Өлгий	тийм	19-3	11-9	
6	Баянхонгор	тийм	19-3	11-9	
7	Булган	тийм	19-3	11-9	
8	Говь-Алтай	тийм	19-3	11-9	
9	Говьсүмбэр	тийм	19-3	11-9	
10	Дархан-Уул	тийм	19-3	11-9	
11	Дорнод	тийм	19-3	11-9	
12	Дорноговь	тийм	19-3	11-9	
13	Дундговь	тийм	19-3	11-9	
14	Төв	тийм	19-3	11-9	
15	Завхан	тийм	19-3	11-9	
16	Орхон	тийм	19-3	11-9	
17	Сэлэнгэ	тийм	19-3	11-9	
18	Сүхбаатар	тийм	19-3	11-9	
19	Увс	тийм	19-3	11-9	
20	Хэнтий	тийм	19-3	11-9	
21	Ховд	тийм	19-3	11-9	
22	Хөвсгөл	тийм	19-3	11-9	
23	Өвөрхангай	тийм	19-3	11-9	
24	Өмнөговь	тийм	19-3	11-9	
25	Нийслэл	тийм	19-3	11-9	

1. Мэдээллийг “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”- аар хүргэх тухай хуулийн заалтын хэрэгжилт:

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд нийт 24 захирагчаас Ерөнхийлөн захирагчийн -1, Төвлөрүүлэн захирагчийн-1, Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газруудын шууд захирагчийн-22 шилэн дансны меню үүсгэж төсөв, санхүүгийн мэдээллийг тухай бүр шууд оруулан, Шилэн дансны тухай хуульд хамаарах нийт байгууллагууд 100% тус цахим хуудсанд мэдээллийг

байршуулсан байна. Мөн тус шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй 24 байгууллагын 3 байгууллага буюу 12.5% нь Улаанбаатар хотод, 21 байгууллага буюу 87.5% нь хөдөө орон нутагт бүртгэлтэй байгууллага бүртгэгдсэн байна.

www.audit.mn нэгдсэн цахим хуудсанд өдөрт дунджаар 470 орчим хандалт, систем ашиглалтанд орсоноос хойш нийт 23777 хандалт бүртгэгдсэн байна. Мөн манай байгууллага сайт дотроо зөвхөн шилэн дансны менюны хандалтыг 7 хоногийн өмнөөс бүртгэж эхэлсэн бөгөөд нийт 57 хандалт бүртгэгдсэн байна.

Цаашид анхаарах асуудлууд:

- Шилэн дансны хууль болон журмын хэрэгжилтийг хангуулах, мэдээллийг өөрийн цахим хуудсанд цаг хугацаанд нь байршуулж хэвшүүлэхтэй холбоотой сургалт, үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулах;
- Байгууллагын өөрийн цахим хуудсанд байршсан шилэн дансны менюг хөгжүүлэх, мэдээлэл тавих нөхцөл бололцоогоор хангаж ажиллах, цаашид мэдээллийг холбогдох програм хангамжаас шууд хөрвүүлэн тавих нөхцлийг бүрдүүлэх;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг танилцуулж байх;
- Байгууллага дотооддоо Мэдээллийн самбарыг тогтмол шинэчилж, үйл ажиллагааг идэвхижүүлэх